ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: АХГ-2022/91/НА-СТА-ТӨА**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.


**Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг**
**Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn**
**Аудитын менежер: Ц.Хосжаргал**
**Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn**
**Аудитор: С.Бат-Эрдэнэ**
**Утас: 261885 Цахим хаяг: baterdenes@audit.gov.mn**
**Гэрээгээр гүйцэтгэсэн: Мишээл-Од Аудит ХХК-ийн**
**Захирал: Т.Одончимэг**
**Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn**



Улаанбаатар хот
2022 он

## Агуулга


1.Аудитын санал дүгнэлт ..... 3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 6

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 6

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан ..... 7

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 8

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл ..... 10

3. Аудитын тайлан ..... 11

3.1 Ерөнхий зүйл ..... 11

3.2 Дотоод хяналт ..... 11

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 11

3.4 Материаллаг байдал ..... 12

4. Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 12

4.1 Байгууллагын үйл ажиллагаа ..... 12

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин ..... 12

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого ..... 13

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15

5.1 Шилэн дансны мэдээлэл ..... 16

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 17

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 17

8. Аудитын илрүүлэлт ..... 18

8.1 Залруулсан алдаа ..... 18

8.2 Төлбөрийн акт ..... 19

8.3 Албан шаардлага ..... 20

8.4 Зөвлөмж ..... 21

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 23

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ХАЦЭХ | Худалдан авсан цахилгаан эрчим хүч |
| ЭХЗХ | Эрчим хүчний зохицуулах хороо |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.15 № 07/596

танай ____________ -ны № ____________ -т

УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Р.ДАГДАН ТАНАА

Хараат бус аудиторын тайлан

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 5,887.7 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа зөрчил тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 2012 онд үүссэн 1,137.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг өмнөх тайланд онуудад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэн, тус орлоготой холбоотой 577.0 сая төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Мөн тус гэрээт ажилтай холбоотой худалдан авсан 560.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг зарцуулаагүй удаан хугацаагаар ашиглалтгүй байна;
- 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 433.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах төлбөрийн акт тогтоосныг компанийн хөрөнгөөс барагдуулж, бэлтгэн нийлүүлэгч компаниудаас авлагыг цуглуулаагүй байсан асуудалд өмнөх оны аудитаар авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй;

- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 34,188.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй;
- Өмнөх оны аудитаар хүргүүлсэн Засгийн газраас баталсан аргачлалын дагуу үнэлж биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх 51,747 метр квадрат 14 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгах, 27,827 метр квадрат 15 газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан сунгалтыг хийлгэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй;
- Эздийн өмчийн бусад хэсэг дансанд тайлагнагдах 2,119.4 сая төгрөгийн газар эзэмших эрхийг дүрмийн сангаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн

зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8-д "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" СТОУС-15 Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого стандартын 31 “Аж ахуйн нэгж нь амласан бараа, үйлчилгээгээ худалдан авагчид нийлүүлснээр гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж нь орлогыг хүлээн зөвшөөрнө” стандартын заалттай нийцэхгүй, иж бүрэн байх, эрх ба үүрэг, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## Асуудлыг онцолсон зүйл

Засгийн газрын 2020 оны “Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” 211 дүгээр тогтоолд цахилгаан эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцан төлөх дүнг өмнөх үеийн мөн үеийн хэрэглээнээс хэтрүүлэхгүй байхаар тусгасан. Харин Эрчим хүчний сайдын 2021 оны А/01 дүгээр тушаалын дагуу “ижил төстэй хэрэглэгчийн өмнөх оны мөн үеийн дунджаас бага хэрэглээтэй байсан бол ижил төстэй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын дундаж хэрэглээтэй дүйцүүлж тогтооно” тушаалын дагуу айл өрхүүдэд өмнөх үеийн хэрэглээнээс 10,599.2 сая төгрөгөөр илүү төлбөрийг төрөөс хариуцан төлсөн байна.

Цахилгаан эрчим хүчний төлбөрийг төр хариуцан төлөх хугацааг сунгасан төлөвлөснөөс илүү хөнгөлөлт эдлүүлсэн болон эх үүсвэрийн хангалтгүй байдлын улмаас 12 дугаар сарын санхүүжилтийг олгоогүй зэргээс шалтгаалан компанийн авлага өсөж, төлбөрийн чадвар буурах, хэрэглэгчдийн цахилгааны хэрэглээг хэмнэлтгүй зарцуулах, төлбөрөө хугацаанд нь төлөхгүй байх хандлагыг нэмэгдүүлсэн зэргээр сөрөг нөлөө үзүүлсэн байна.

## Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулах ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тус компанийн цахилгааны барилга байгууламж, ХТП, РП-д хамаарах зарим газар бусад хувь хүн, хуулийн этгээдийн нэр дээр бүртгэлтэй байгаа нь цаашид газрын маргаантай асуудал үүсэх, төрийн өмч эзэмших эрхээ алдах эрсдэл үүссэн байна.

**Бусад асуудал**

Эрчим хүчний Сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд нийт орлогыг 529,786.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 536,613.3 сая төгрөгөөр, алдагдлыг 6,826.4 сая төгрөгөөр баталсан байна.

Гүйцэтгэлээр 566,782.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 566,840.9 сая төгрөгийн зардал гарган, 58.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Зорилтот түвшнийг батлахдаа үндсэн хөрөнгийн элэгдлийг бодит байдлаас багаар баталдгаас компанийн зардал хэтэрч, алдагдал нэмэгдэхэд нөлөөлж байна.

**Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 223 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэл 100.0 хувьтай гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

9006109

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\20220315 Auditiin 2 Gazar - 72.Docx

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ХӨРӨНГӨ** | | |
| **1.1** | **Эргэлтийн хөрөнгө** | | |
| 1.1.1 | Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө | 787,006,132.96 | 2,486,900,045.92 |
| 1.1.2 | Дансны авлага | 37,926,138,648.16 | 74,466,818,571.11 |
| 1.1.3 | Татвар, НДШ – ийн авлага | | 1,211,242,839.98 |
| 1.1.4 | Бусад авлага | 21,264,038,490.91 | 1,865,706,496.05 |
| 1.1.5 | Бусад санхүүгийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.6 | Бараа материал | 8,726,687,325.63 | 11,536,939,004.91 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 111,090,173.40 | 34,970,065.19 |
| 1.1.8 | Бусад эргэлтийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.1.9 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) | 0.00 | 0.00 |
| 1.1.10 | | | |
| 1.1.11 | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **68,814,960,771.06** | **91,602,577,023.16** |
| **1.2** | **Эргэлтийн бус хөрөнгө** | | **0.00** |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 270,316,897,047.96 | 294,983,296,297.98 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | 2,668,475,805.23 | 2,924,181,197.07 |
| 1.2.3 | Биологийн хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 0.00 | 0.00 |
| 1.2.5 | Хайгуул ба үнэлгээний хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.6 | Хойшлогдсон татварын хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.7 | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 0.00 | 0.00 |
| 1.2.8 | Бусад эргэлтийн бус хөрөнгө | 565,884,831.95 | 508,091,685.47 |
| 1.2.9 | | | |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **273,551,257,685.14** | **298,415,569,180.52** |
| **1.3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **342,366,218,456.20** | **390,018,146,203.68** |
| **2** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | |
| **2.1** | **Өр төлбөр** | | |
| 2.1.1 | **Богино хугацаат өр төлбөр** | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 44,163,819,334.83 | 65,039,204,049.86 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 2,700,125,492.80 | 3,821,726,958.65 |
| 2.1.1.3 | Татварын өр | 781,077,696.98 | 712,149,958.98 |
| 2.1.1.4 | НДШ – ийн өглөг | 693,249,251.89 | 0.00 |
| 2.1.1.5 | Богино хугацаат зээл | 0.00 | 0.00 |
| 2.1.1.6 | Хүүний өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.7 | Ногдол ашгийн өглөг | 0.00 | 0.00 |
| 2.1.1.8 | Урьдчилж орсон орлого | 4,275,206,247.68 | 2,119,900,074.26 |
| 2.1.1.9 | Нөөц/өр төлбөр/ | 0.00 | 0.00 |
| 2.1.1.10 | Бусад богино хугацаат өр төлбөр | 5,241,828,683.22 | 702,526,770.22 |
| 2.1.1.11 | Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) - нд хамаарах өр төлбөр | 0.00 | 0.00 |
| 2.1.1.12 | | | |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **57,855,306,707.40** | **72,395,507,811.97** |
| **2.1.2** | **Урт хугацаат өр төлбөр** | **0.00** | **0.00** |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 30,871,430,749.81 | 29,691,931,104.58 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | 0.00 | 0.00 |
| 2.1.2.3 | Хойшлогдсон татварын өр | 3,601,197,613.95 | 5,285,690,831.64 |
| 2.1.2.4 | Бусад урт хугацаат өр төлбөр | 25,816,899,190.69 | 27,531,554,491.20 |
| 2.1.2.5 | | | |

| | | | |
|---|---|---|---|
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **60,289,527,554.45** | **62,509,176,427.42** |
| 2.2 | **Өр төлбөрийн нийт дүн** | **118,144,834,261.85** | **134,904,684,239.39** |
| **2.3** | **Эздийн өмч** | | 0.00 |
| 2.3.1 | Өмч:-төрийн | 118,530,858,480.10 | 179,737,275,206.59 |
| 2.3.2 | хувийн | 0.00 | 0.00 |
| 2.3.3 | хувьцаат | 0.00 | 0.00 |
| 2.3.4 | Халаасны хувьцаа | 0.00 | 0.00 |
| 2.3.5 | Нэмж төлөгдсөн капитал | 0.00 | 0.00 |
| 2.3.6 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 48,119,356,491.94 | 46,363,120,605.48 |
| 2.3.7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц | 0.00 | 0.00 |
| 2.3.8 | Эздийн өмчийн бусад хэсэг | 61,206,416,726.49 | 33,043,804,537.27 |
| 2.3.9 | Хуримтлагдсан ашиг | (3,635,247,504.18) | (4,030,738,385.05) |
| 2.3.10 | | | |
| **2.3.11** | **Эздийн өмчийн дүн** | **224,221,384,194.35** | **255,113,461,964.29** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **342,366,218,456.20** | **390,018,146,203.68** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | Үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Борлуулалтын орлого (цэвэр)** | **489,264,824,318.51** | **556,279,768,934.60** |
| 2 | Борлуулалтын өртөг | **462,068,253,902.02** | **521,533,781,587.18** |
| **3** | **Нийт ашиг( алдагдал)** | **27,196,570,416.49** | **34,745,987,347.42** |
| 4 | Түрээсийн орлого | 11,153,884.29 | 34,937,272.72 |
| 5 | Хүүний орлого | 42,101,760.66 | |
| 6 | Ногдол ашгийн орлого | | |
| 7 | Эрхийн шимтгэлийн орлого | | |
| 8 | Бусад орлого | 13,635,008,987.48 | 10,467,695,977.03 |
| 9 | Борлуулалт, маркетингийн зардал | 26,990,292,577.56 | 26,633,001,011.98 |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | 10,446,886,237.42 | 11,307,687,633.48 |
| 11 | Санхүүгийн зардал | 518,822,603.89 | 483,912,702.34 |
| 12 | Бусад зардал | 13,741,637,068.01 | 6,882,517,071.12 |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 40,826.32 | |
| 14 | Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 15 | Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | | |
| 16 | Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | | |
| **17** | Бусад ашиг ( алдагдал) | | |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг( алдагдал)** | **(10,812,762,611.64)** | **(58,497,821.75)** |
| **19** | Орлогын татварын зардал | 528,948,173.02 | 1,724,341,296.87 |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(11,341,710,784.66)** | **(1,782,839,118.61)** |
| **21** | **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | | |
| **22** | **Тайлант үеийн цэвэр ашиг ( алдагдал)** | **(11,341,710,784.66)** | **(1,782,839,118.61)** |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **118,530,858,480.10** | **48,677,809,806.83** | **18,254,874,358.07** | **7,117,709,965.55** | **192,581,252,610.55** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - | 30,300,000.04 | **30,300,000.04** |
| **Залруулсан үлдэгдэл** | **118,530,858,480.10** | **48,677,809,806.83** | **18,254,874,358.07** | **7,148,009,965.59** | **192,611,552,610.59** |
| Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал) | - | - | - | (11,341,710,784.66) | **(11,341,710,784.66)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | - | - | **-** |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | (558,453,314.89) | 42,951,542,368.42 | | **42,393,089,053.53** |
| Зарласан ногдол ашиг | - | - | - | - | **-** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | - | - | 558,453,314.89 | **558,453,314.89** |
| **2020 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл** | **118,530,858,480.10** | **48,119,356,491.94** | **61,206,416,726.49** | **(3,635,247,504.18)** | **224,221,384,194.35** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | | | | (368,887,648.70) | **(368,887,648.70)** |
| **Залруулсан үлдэгдэл** | **118,530,858,480.10** | **48,119,356,491.94** | **61,206,416,726.49** | **(4,004,135,152.88)** | **223,852,496,545.65** |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | | | | (1,782,839,118.61) | **(1,782,839,118.61)** |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | 61,206,416,726.49 | | (28,162,612,189.22) | | **33,043,804,537.27** |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | (1,756,235,886.46) | | 1,756,235,886.46 | **-** |
| **2021 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл** | **179,737,275,206.59** | **46,363,120,605.48** | **33,043,804,537.27** | **(4,030,738,385.05)** | **255,113,461,964.29** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Мөрийн дугаар | ҮЗҮҮЛЭЛТ | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | **Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | 0.00 | 0.00 |
| 1.1 | **Мөнгөн орлогын дүн (+)** | **493,618,003,565.01** | **530,071,405,647.18** |
| | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 428,992,471,587.63 | 488,737,494,227.27 |
| | Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | 0.00 | 0.00 |
| | Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | 482,396,365.00 | 467,625,640.15 |
| | Буцаан авсан албан татвар | 35,000.00 | 0.00 |
| | Татаас, санхүүжилтийн орлого | 0.00 | 0.00 |
| | Бусад мөнгөн орлого | 64,143,100,612.38 | 40,866,285,779.76 |

| | | | |
|---|---|---|---|
| **1.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **487,924,089,208.86** | **525,235,117,468.14** |
| | Ажиллагчдад төлсөн | 38,947,429,621.96 | 35,936,879,374.09 |
| | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 10,393,600,899.98 | 12,520,528,941.73 |
| | Бараа материал худалдан авахад төлсөн | 12,054,670,433.53 | 11,593,356,038.68 |
| | Ашиглалтын зардалд төлсөн | 1,313,763,410.86 | 1,292,862,285.39 |
| | Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 2,039,256,001.20 | 1,823,330,173.09 |
| | Хүүний төлбөрт төлсөн | 627,398,099.77 | 684,269,721.17 |
| | Татварын байгууллагад төлсөн | 7,694,295,665.31 | 10,730,057,780.89 |
| | Даатгалын төлбөрт төлсөн | 123,302,435.00 | 161,817,353.00 |
| | Бусад мөнгөн зарлага | 414,730,372,641.25 | 450,492,015,800.10 |
| **1.3** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **5,693,914,356.15** | **4,836,288,179.04** |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | 0.00 | 0.00 |
| **2.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **42,101,760.66** | **0.00** |
| | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| | Биет бус хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| | Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| | Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | 0.00 | 0.00 |
| | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 0.00 | 0.00 |
| | Хүлээн авсан хүүний орлого | 42,101,760.66 | 0.00 |
| | Хүлээн авсан ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| **2.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **4,715,409,184.39** | **1,961,505,903.47** |
| | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 4,715,409,184.39 | 1,961,505,903.47 |
| | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| | Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| | Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 0.00 | 0.00 |
| | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 0.00 | 0.00 |
| **2.3** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(4,673,307,423.73)** | **(1,961,505,903.47)** |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | 0.00 | 0.00 |
| **3.1** | **Мөнгөн орлогын дүн (+)** | **0.00** | **0.00** |
| | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| | Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 0.00 | 0.00 |
| | Төрөл бүрийн хандив | 0.00 | 0.00 |
| **3.2** | **Мөнгөн зарлагын дүн (-)** | **2,349,776,725.22** | **1,174,888,362.61** |
| | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 2,349,776,725.22 | 1,174,888,362.61 |
| | Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн | 0.00 | 0.00 |
| | Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн | 0.00 | 0.00 |
| | Төлсөн ногдол ашиг | 0.00 | 0.00 |
| **3.3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(2,349,776,725.22)** | **(1,174,888,362.61)** |
| **4** | Валютын ханшийн зөрүү | **40,826.32** | |
| 5 | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **1,329,128,966.48** | **1,699,893,912.96** |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,116,135,099.44** | **787,006,132.96** |
| **7** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **787,006,132.96** | **2,486,900,045.92** |

## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

| д/д | Үзүүлэлтүүд | хэмжих нэгж | 2020 оны гүйцэтгэл | 2021 он | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Төлөвлөгөөтэй | |
| | | | | | | дүн | хувь |
| 1 | Худалдаж авсан цахилгаан | мян.кВт.ц | 3,070,332.3 | 3,303,794.8 | 3,520,855.7 | 217,060.9 | 6.6% |
| 2 | ЦЭХ-ний алдагдал: хувиар | хувь | 14.72% | 14.65% | 13.44% | (0.0) | 8.3% |
| | Биетээр | мян.кВт.ц | 451,823.4 | 484,003.8 | 473,037.6 | (10,966.2) | 2.3% |
| 3 | Борлуулах цахилгаан эрчим хүч | мян.кВт.ц | 2,618,508.9 | 2,819,791.0 | 3,047,818.2 | 228,027.2 | 8.1% |
| 4 | **Нийт орлого** | **мян.төг** | **502,953,129.8** | **529,786,900.0** | **566,782,402.2** | 36,995,502.2 | 7.0% |
| | Үүнээс: Борлуулалтын орлого | мян.төг | 422,765,285.0 | 458,272,100.0 | 487,479,548.7 | 29,207,448.7 | 6.4% |
| | Түгээх үйлчилгээний төлбөр | мян.төг | 66,499,539.3 | 62,715,700.0 | 68,800,220.2 | 6,084,520.2 | 9.7% |
| | Үйл ажиллагааны бус орлого | мян.төг | 13,688,305.5 | 8,799,100.0 | 10,502,633.2 | 1,703,533.2 | 19.4% |
| 5 | **Нийт зардал** | **мян.төг** | **513,765,892.4** | **536,613,300.0** | **566,840,900.0** | 30,227,600.0 | 5.6% |
| | Үүнээс: ХАЦ-ын өртөг | мян.төг | 422,090,191.7 | 451,357,700.0 | 478,371,757.5 | 27,014,057.5 | 6.0% |
| | Үндсэн үйл ажиллагааны зардал | мян.төг | 77,934,063.6 | 77,081,400.0 | 81,586,625.4 | 4,505,225.4 | 5.8% |
| | Үйл ажиллагааны бус зардал | мян.төг | 13,741,637.1 | 8,174,200.0 | 6,882,517.1 | (1,291,682.9) | 15.8% |
| 6 | Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/ | мян.төг | (10,812,762.6) | (6,826,400.0) | (58,497.8) | 6,767,902.2 | 99.1% |
| | Орлогын татварын зардал | мян.төг | 528,948.2 | - | 1,637,758.2 | 1,637,758.2 | |
| | **Цэвэр ашиг /алдагдал/** | **мян.төг** | **(11,341,710.8)** | **(6,826,400.0)** | **(1,696,256.0)** | 5,130,144.0 | 75.2% |
| 7 | Төрийн өмчийн ногдол ашиг | мян.төг | - | - | - | 0.0 | |
| 8 | Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | төгрөг | 1.02 | 1.01 | 1.00 | (0.0) | 1.3% |
| 9 | Нийт авлага | мян.төг | 59,190,100.0 | 43,359,882.9 | 78,697,617.0 | 35,337,734.1 | 81.5% |
| | Үүнээс: Цахилгааны авлага | мян.төг | 26,500,000.0 | 33,940,882.9 | 74,466,818.0 | 40,525,935.1 | 119.4% |
| 10 | Нийт өр төлбөр | мян.төг | 88,944,527.6 | 95,766,900.0 | 132,757,336.0 | 36,990,436.0 | 38.6% |
| | Үүнээс: Богино хугацаат өглөг | мян.төг | 28,655,000.0 | 32,100,000.0 | 73,849,358.0 | 41,749,358.0 | 130.1% |
| | Урт хугацаат өр төлбөр | мян.төг | 60,289,527.6 | 63,666,900.0 | 58,907,978.0 | (4,758,922.0) | 7.5% |
| 11 | Хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ | мян.төг | 8,921,625.7 | 13,853,500.0 | 16,538,681.3 | 2,685,181.3 | 19.4% |
| 12 | Нийт ажиллагсадын тоо | хүн | 1,920.0 | 1,920.0 | 1,920.0 | 0.0 | 0.0% |
| 13 | Нийт цалингийн сан | мян.төг | 38,039,608.3 | 38,621,100.0 | 38,933,505.6 | 312,405.6 | 0.8% |
| | Нэг ажиллагчийн дундаж цалин | мян.төг | 1,651,168.0 | 1,519,641.4 | 1,545,155.7 | 25,514.3 | 1.7% |
| 14 | Цахилгаан тасалдлын дундаж хугацаа Исайди | минут | 951.60 | 1,230.00 | 926.47 | (303.5) | 24.7% |
| 15 | Дундаж үнэ | төгрөг | 161.45 | 162.52 | 160.99 | (1.5) | 0.9% |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад насжилт өндөртэй бараа материалыг эргэлтэд оруулж хөрөнгийг үр ашигтай зарцуулах, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох, цалин хөлсийг татвар нийгмийн даатгалын тайланд зөрүүгүй тайлагнах, гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт зорилтот бүлэгт үзүүлэх, үлдэгдлийг баталгаажуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Цогзолмаа, О.Цэндхүү, аудитор М.Батмагнай, аудиторын туслах Э.Ундрах-Эрдэнэ, С.Номин, Б.Болорчимэг, Т.Алтанчимэг, Б.Амаржаргал нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланг Мишээл-Од Аудит ХХК-д 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 1/235 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Эрчим хүчний яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас цахилгаан эрчим хүчний хөнгөлөлттэй холбоотой шалгалт хийж, ерөнхий чиглэл өгч ажилласан.

Дотоод аудитор тайлант онд Засгийн газрын хөнгөлөлтийн тооцооллыг бүх хэрэглэгчдэд үйлчлэх төвүүдийг хамруулан шалгаж залруулгыг хийж ажилласан байна. Мөн салбаруудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж зөвлөмж өгч, ажилласан боловч төв компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагатай гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 502,953.1 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,029.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн зорилгыг “Чадварлаг ажилтнуудаар чанартай үйлчилгээг хэрэглэгчдэдээ хүргэж, цахилгаан эрчим хүчийг найдвартай түгээгч, аюулгүй ажиллагааг хангасан салбартаа тэргүүлэгч компани болоход оршино” гэж тодорхойлжээ.

Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг “Цахилгаан эрчим хүч түгээх, цахилгаан эрчим хүчээр зохицуулалттай хангах, тусгай зөвшөөрлийн хүрээнд компанийн эзэмшлийн түгээх сүлжээ, шугам тоноглолын ашиглалт, засвар үйлчилгээ, өргөтгөл, шинэчлэлийн ажлуудыг чанартай гүйцэтгэж хэрэглэгчийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг хангах, цахилгаан эрчим хүчийг хэрэглэгчдэд хамгийн бага алдагдалтайгаар борлуулж, борлуулалтын орлогыг бүрэн цуглуулах, хэрэглэгчдэд үйлчлэх үйлчилгээг хэрэглэгчийн сэтгэл ханамжийг бүрэн хангасан түвшинд зохион байгуулахад оршино” гэж тусгасан байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Төрийн өмчит хувьцаат компани статустай байна. Өмчийн 100.0 хувийг төр, үүнээс Эрчим хүчний яам 70.0 хувь, Төрийн өмчийн Бодлого зохицуулалтын газар 30.0 хувийг эзэмшиж байна.

### 4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийг Засгийн газрын 2001 оны 164 дүгээр тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хувьцаа эзэмшигчид томилж байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх гишүүний нэрийг төрийн эзэмшлийн хувьцааг эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлж байгаа этгээд тухайн компанийн нэр дэвшүүлэх хороонд санал болгох …” гэсэн заалттай нийцэж байна.

Тус компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 0.8 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан

Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10-т "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно" гэж заасан байна. Энэ хүрээнд хөрөнгийн дахин үнэлгээг хийж, цар тахлын нөхцөл байдалтай холбоотой Эрчим хүчний салбар байнгын өндөржүүлсэн бэлэн байдалд ажилласан ба ямар нэгэн бүтэц зохион байгуулалт болон засаглалын түвшинд өөрчлөлт хийхгүй байхыг ЭХЯ-аас чиглэл болгосон тул чиглэлийн дагуу ажилласан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3 -д заасны дагуу 2016 оноос үйл ажиллагааны цар хүрээ 21.0 хувиар өссөн боловч орон тоог нэмэгдүүлэлгүйгээр дотоод зохион байгуулалтын бүтцийн хувьд 33 кассаас 11 кассыг хэвээр үлдээж, 17 кассын орон тоог шаардлагатай байгаа нэгжүүдэд шилжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай"
- ЗГ-ын 2021 оны 207 дугаар тогтоол "Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай"
- УБЦТС ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны А/04 тоот тушаал "Монгол улсын засгийн газраас хариуцах төлбөрийг тооцоолох аргачлал"
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу бараа материал болон авлагын хасагдуулгын хувь хэмжээнд өөрчлөлт оруулсан

## 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 787,006.1 | 2,486,900.0 | 1,699,893.9 |
| Авлага | 59,190,177.1 | 77,543,767.9 | 18,353,590.7 |
| Урьдчилгаа | 111,090.1 | 34,970.0 | (76,120.1) |
| Бараа материал | 8,726,687.3 | 11,536,939.0 | 2,810,251.6 |
| Үндсэн хөрөнгө | 270,316,897.0 | 294,983,296.3 | 24,666,399.2 |
| Биет бус хөрөнгө | 2,668,475.8 | 2,924,181.2 | 255,705.3 |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | 565,884.8 | 508,091.6 | (57,793.1) |
| **Нийт хөрөнгийн дүн** | **342,366,218.4** | **390,018,146.2** | **47,651,927.7** |
| Өр төлбөрийн дүн | 118,144,834.2 | 134,904,684.2 | 16,759,849.9 |
| Богино хугацаат өглөг | 57,855,306.7 | 72,395,507.8 | 14,540,201.1 |
| Урт хугацаат өглөг | 60,289,527.5 | 62,509,176.4 | 2,219,648.8 |
| Эздийн өмч | 224,221,384.1 | 255,113,461.9 | 30,892,077.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **342,366,218.4** | **390,018,146.2** | **47,651,927.7** |

Касс дахь бэлэн мөнгө 18.4 сая, банк дахь харилцах дансанд 3,461.9 сая, замд яваа мөнгөн хөрөнгө 6.5 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэлд цахилгаан эрчим хүчний авлага 74,466.8 сая, татвар НДШ-ийн авлага 1,211.2 сая төгрөг, бусад авлага 1,865.7 сая төгрөгийг тус тус эзэлж байна.

Тайлант онд цахилгаан эрчим хүчний төлбөрийг төрөөс хариуцан төлөхтэй холбоотойгоор Засгийн газраас авах авлага 31,519.0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь авлагын өсөлтөд голлон нөлөөлжээ.

Авлагын үлдэгдэлд хугацаандаа байгаа 73,271.9 сая төгрөгийн, хугацаа хэтэрсэн 4,271.8 сая төгрөгийн найдваргүй авлага байна. Найдваргүй авлагын үлдэгдлийн нөөцийн аргаар тооцдог байна. Тайлант онд хасагдуулах тооцох хувь хэмжээнд өөрчлөлт орсонтой холбоотойгоор 706.2 сая төгрөгийн найдваргүй авлагын нөөцийг бууруулж, Налайх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 104/ШШ2021/00001 тоот шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 25 дугаар тогтоолоор 55 хэрэглэгчийн 16.2 сая төгрөгийн найдваргүй авлагыг данснаас хассан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 11,536.9 сая төгрөг болж 2,810.3 сая төгрөгөөр өссөн нь бараа материалын хасагдуулгын хувь хэмжээг тайлант онд бууруулж, шинэчлэн баталсан, мөн оны эцэст 1,323.0 сая төгрөгийн худалдан авалт хийж бараа материалын нөөц үүсгэсэн нь Ковид-19 цар тахлын улмаас импортын барааны ачаа тээврийн хугацаа удааширснаас оны төгсгөлд бараа материал нийлүүлэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэлд 1,152.5 сая төгрөгийн үнэ цэний бууралт үүссэн гэж тооцон бараа материалын хасагдуулгаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Үүнээс насжилт өндөртэй буюу 10 жилээс дээш насжилттай 964.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, бараа материалын нөөц бүрдүүлэн худалдан авалт хийсэн байна.

Үндсэн хөрөнгө худалдан авсан 1,605.8 сая, их засварын капиталжуулалт 6,189.7 сая, балансаас балансt шилжүүлэн авсан 4,471.2 сая, улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээ 28,990.0 сая, иргэд хуулийн этгээдээс хүлээн авсан 2,437.7 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, ТӨБЗГ-ын газрын 2020 оны 520 тогтоолоор худалдан борлуулсан 36.1 сая, 2021 оны 526, 587 дугаар тогтоол, А-1/1403 дугаар албан бичгээр акталсан 936.2 сая, ангилал хооронд залруулсан 2,704.1 сая төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдэл 57.8 сая төгрөгөөр буурч 491.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тайлант хугацаанд зээлийн эргэн төлөгдөх хуваарийн дагуу авлага цугласантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 72,395.5 сая төгрөгийн өр төлбөр байна.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2004 болон 2010 онд Дэлхийн банкны дамжуулан зээлээс үүссэн 29,691.9 сая төгрөгийн өр төлбөрөөс тайлант оны эргэн төлөгдөх хуваарийн дагуу 2,349.8 сая төгрөгийг төлөхөөс 1,174.9 сая төгрөгийг төлсөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн эргэн төлөлт хугацаандаа хийгдэхгүй байгаа нь Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоол, “Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 207 дугаар тогтоолын Засгийн газраас хариуцах төлбөр нь хугацаандаа төвлөрөөгүйн улмаас компанид тооцогдох санхүүжилт удааширсантай холбоотой байна. Энэ нь компанийн мөнгөн урсгалын төлөвлөгөө алдагдах, нэмэлт хүү алдангийн зардал гарах үр дагавартай байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал 3 гэж ангилсан байна.

Зардал өмнөх онтой харьцуулахад 3,652.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь цалингийн зардал болон ХАЦЭХ-ийн өртөг борлуулалт өссөнөөс шалтгаалж нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт худалдан авсан цахилгаан эрчим хүчний өртөг болон түгээх үйл ажиллагааны зардлуудыг хамруулсан байна. Эрчим хүчний салбарын компаниудын НББББББ-т заасан нь зөрчигдөөгүй байна.

### 4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Эрчим хүчний Сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 529,786.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 536,613.3 сая төгрөгөөр, 6,826.4 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 13,853.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна. Эрчим хүчний сайдын 2021 оны А/190 дүгээр тушаалаар 2021 оны их засвар, хөрөнгө оруулалт, ТЗБАХ-д 73 нэр төрлийн 135 ажлыг 16,779.5 сая төгрөг зарцуулахаар тодотгожээ.

Гүйцэтгэлээр 566,782.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 566,840.9 сая төгрөгийн зардал гарган, 58.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 566,782.4 сая төгрөг болж төлөвлөснөөс 36,995.5 сая төгрөг буюу 7.0 хувиар давсан бөгөөд борлуулалтын орлого 29,207.4 сая төгрөгөөр буюу 6.4 хувиар, үндсэн бус үйл ажиллагааны орлого 1,703.5 сая төгрөгөөр буюу 19.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 566,840.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 30,227.6 сая төгрөг буюу 5.6 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Үүнд ХАЦ-ын өртөг 27,014.1 сая төгрөг буюу 6.0 хувиар, үндсэн үйл ажиллагааны зардал 4,505.2 сая төгрөг буюу 5.8 хувиар өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 73 нэр төрлийн 135 ажилд өөрийн эх үүсвэрээс 16,538.7 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд алдагдал 1,696.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 5,130.1 сая төгрөгөөр буурахад үндсэн үйл ажиллагааны алдагдал 3,772.7 сая төгрөгөөр буурч, үндсэн бус үйл ажиллагааны ашиг 2,995.2 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлж байна.

ТӨБЗГ-т өмнөх онд алдагдалтай ногдол ашиг хуваарилж, төвлөрүүлээгүй ба түрээсийн орлогын 40 хувь буюу 18.8 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК нь нийт 2,382,885.8 сая төгрөгийн 4257 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг хэсэгт 33 харилцагчтай холбоотой 625.3 сая санхүүжилтийн мэдээллийг ил тод байршуулаагүй зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Өмнөх оны аудитаар хүргүүлсэн худалдан авах ажиллагааны үнэлгээг хуульд заасны дагуу үнэлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 1,699.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээг буруу хийсэн. Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна" 47.2.2 "тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх" заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт бүрээр үнэлгээг үнэн зөв хийх, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх

Цалингийн зардлыг 312.4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, оны тэргүүний ажилтнуудыг шалгаруулан шилдэг ажилтнууд болон алба, хэлтэст 129.6 сая төгрөгийн шагнал урамшуулал олгосон, бэлэг дурсгалын зардалд 85.7 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах;" 1.3-д "...цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг мөрдөж ажиллан, тэвчиж болох зардлыг тэвчиж, зардлыг хэмнэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлага хүргүүлэх

Илүү цагийн нэмэгдэл олгох хязгаарыг хэтрүүлэн 6.6 сая төгрөгийн илүү цагийн хөлс тооцож олгосон. Хамтын гэрээнд хэвийн бус нөхцөлийн ажилтнуудад хамаарах амралтын хоногийг хөдөлмөрийн хуульд заасныг 1 хоногоор илүү амраахаар заасан. Тайлант онд цахилгаан, дулааны төлбөрийг төр хариуцан төлсөн байхад нийт 233.5 сая төгрөгийн "халаалтын улирлын хөнгөлөлт"-ийг бүх ажилтан болон ахмадуудад засгийн газрын хөнгөлөлттэй давхардуулан олгосон. Мөн нийт орон тооны 38.3 хувь нь удирдах, ахлах ажилтнууд эзэлсэн буюу удирдах ажилтнууд олон дэд захирлууд болон алба, хэлтсийн дарга нарын ажлын ачаалал эрс ялгаатай байна.

Энэ нь Хөдөлмөрийн дотоод журмын 10.2.8 "Ажилтанд илүү цагийг тооцон нэмэгдэл олгох хэмжээ нь тухайн сард ажиллавал зохих цагийн 30 хувиас хэтрэхгүй байна" Хөдөлмөрийн хуулийн 99 дүгээр зүйлийн "99.6.Хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллаж байгаа

ажилтанд түүний ажилласан хугацааг харгалзан ээлжийн үндсэн амралтын хугацаан дээр нь дараах нэмэгдэл амралтыг олгоно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү цагийн нэмэгдэл хөлсийг дотоод журамд заасан хязгаарт багтаан олгох, ээлжийн амралт эдлэх хоногийг хөдөлмөрийн хуульд заасантай нийцүүлэх, шагнал, урамшуулал, тэтгэмжийг хавтгайруулан их хэмжээгээр олгохгүй байх, удирдах ажилтнуудын үр дүн, хариуцаж буй ажил үүргийг үнэлэн удирдах ажилтнуудыг нэмэгдүүлэхгүйгээр, гүйцэтгэх ажилтан руу шилжүүлэх байдлаар орон тоо зардлыг хэмнэж ажиллах талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд худалдан авалтын мэдээллийг дутуу байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай, тендер шалгаруулалтын үнэлгээг буруу хийсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн холбогдох заалттай, ажилтнуудад шагнал урамшуулал олгож, баяр ёслолын зардал гаргасан, тэтгэмжийг хавтгайруулан олгосон нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын холбогдох заалттай, утааны хөнгөлөлт нь зорилтот хэрэглэгчдэдээ хүрч чадаагүй, эх үүсвэр тодорхойгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 69,704.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 66,511.4 сая төгрөгийн алдааг залруулж, 1,329.6 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 1,863.3 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 38.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 19,620.9 сая төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 9,965.5 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмж өгснөөс төлбөрийн акт 100.0 хувь, албан шаардлага 42.8 хувь, зөвлөмж 85.7 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 2.* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 38.2 | 1 | 38.2 | | | 100.0 |
| Албан шаардлага | 7 | 19,620.9 | 2 | 15,130.2 | 5 | 4,490.7 | 28.5 |
| Зөвлөмж | 7 | 9,965.5 | 6 | 9,676.5 | 1 | 289.0 | 85.7 |
| Нийт дүн | 15 | 29,624.6 | 9 | 24,844.9 | 6 | 4,779.7 | 60.0 |

Шилэн дансны мэдээллийг иж бүрэн, хугацаанд нь мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, газар эзэмших эрхийг үнэлж бүртгэлд тусгах, тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн баримт бичигт заасны дагуу үнэн зөв хийх, авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах, авлагыг барагдуулах зэрэг 5 албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байгаа тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүллээ.

Компанийн үйл ажиллагаанд ашиглаагүй, ажилтнуудад олгосон орон сууцыг данснаас хасах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дээд шатны захирагчийн анхааралд хандуулах дараах асуудал байна. Үүнд:

- Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолуууртай өрхийн

орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг хөнгөлж, тайлант онд дунджаар 120279 хэрэглэгчийг хөнгөлөлтөд хамруулан 16,088.4 сая төгрөгийн хөнгөлөлтийг эдлүүлсний 1.2 хувийг хамарсан 1504 хэрэглэгч нь нийт хөнгөлөлтийн 11.6 хувь буюу 1,860.3 сая төгрөгийг, 98.7 хувийг хамарсан 118,775 хэрэглэгч нь 88.7 хувь буюу 14,228.0 сая төгрөгийн хөнгөлөлтийг эдэлсэн. Гэр хороололд амьдардаг иргэдийн дийлэнх нь халаалтаа цахилгаанаар хангах шийдлийг гаргах хөрөнгийн эх үүсвэргүйгээс хөнгөлөлтөд хамрагдаж чадаагүй, харин хотын гадна цэвэр агаарын бүсэд амьдарч буй өндөр хэрэглээтэй хувийн орон сууц, хаус, хотхонд амьдарч буй төлбөрийн чадвартай иргэд дийлэнх хөнгөлөлтийг эдэлсэн;

- Хөнгөлөлтийн төлбөрийн эх үүсвэр нь ЭХЯ-аар дамжин БОАЖЯ-ны агаарын бохирдлыг бууруулах сангаас төлөгддөг бөгөөд оны эцсийн байдлаар 13,675.1 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, өмнөх оноос 2 дахин өссөн.

Үүнээс үзэхэд хөнгөлөлтийн зорилго хангалтгүй хөнгөлөлт эдлэх шаардлагатай хэрэглэгчид хөнгөлөлтийг эдлэх боломж хязгаарлагдмал, эх үүсвэр хүрэлцэхгүй их хэмжээний авлагатай байхад хөнгөлөлтийн ихэнх хувийг төлбөрийн чадвартай иргэд эдэлсэн, утааг их хэмжээгээр үйлдвэрлэж буй ихэнх хэрэглэгч амьдардаг гэр хорооллын иргэд цахилгаанаар дулаанаа шийдэх боломжгүй байгаагаас утаа буурахгүй байгаа байдалд судалгаа, шинжилгээ, дүгнэлт хийгээгүй байна. Иймд хөнгөлөлт олгох журмыг дахин нягталж, дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд журамд шинэчлэлт өөрчлөлт оруулах, БОАЖЯ-с авах авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авч ажиллах, эх үүсвэрийг тодорхой болгох шаардлагатай байна.

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг авч үзнэ. Үүнд:

- Ажлаас үндэслэлгүй халагдсан тул ажилдаа эргүүлэн томилох, ажилгүй байх хугацааны нөхөн олговрыг авах асуудлаар тус компанийн нэг ажилтан шүүхээр шийдвэрлүүлэхээр хандсан, шүүхийн шийдвэр эцэслэн гараагүй;
- Тус компанийн нэр дээр бүртгэлтэй газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа нь дуусаагүй байхад “дулааны шугамын хамгаалалтын зурвасын бүс” шалтгаанаар эзэмших эрхийн гэрчилгээг цуцалсан боловч үүний дараа газар эзэмших эрхийг дуудлага худалдаагаар зарж борлуулан иргэнд эзэмшүүлсэн байна. Одоогийн газар эзэмшигч нь тухайн газар дээр байрлалтай тус компанийн өмчлөлийн аж ахуйн бетонон хашааг нүүлгэх шаардлага тавиад байгаа тул тухайн асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхээр төлөвлөсөн;
- Тайлант хугацаанд компанийн дүрмийн сангийн хэмжээг 61,206.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн боловч улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлтийг оруулаагүй;
- Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор гэр хорооллын айл өрхөд утааны хөнгөлөлт үзүүлэхдээ аж ахуйн нэгж байгууллагын нэр дээр бүртгэлтэй хувийн орон сууцанд хөнгөлөлт үзүүлсэн зэрэг асуудлуудыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

## 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 82,584.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 76,697.0 сая төгрөгийн 12 алдааг залруулж, 300.2 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт тогтоож, 1,208.0сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 4,379.5 сая төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 5,887.7 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 5,029.5 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай “дүгнэлт өглөө.

### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 76,697.3 сая төгрөгийн 12 алдааг залрууллаа. Үүнд:

- НББОУС-12 Орлогын албан татвар стандартын 12 “Тухайн тайлант болон өмнөх тайлант хугацаанд хамаарах тайлант үеийн татварыг түүний төлөгдөөгүй байгаа

дүнгээр өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцүүлээгүй, татварын зардлыг зөрүүтэй тооцсоноос орлогын татварын зардал 304.0 сая төгрөгөөр илүү тайлагнасан;

- НББОУС-12 Орлогын албан татвар стандартын 12 "Тухайн тайлант болон өмнөх тайлант хугацаанд хамаарах тайлант үеийн татварыг түүний төлөгдөөгүй байгаа дүнгээр өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцүүлээгүй, 3,076.0 сая төгрөгийн хойшлогдсон татварын өр төлбөрийг холбогдох шийдвэр, үндэслэлгүйгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулга данс руу хааж бүртгэсэн;
- НББОУС 16 "Үндсэн хөрөнгө" 41-т Үндсэн хөрөнгийн зүйлтэй холбоотойгоор өмчид тусгагдсан дахин үнэлгээний нэмэгдлийг тухайн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх (буюу данснаас хасах) үед хуримтлагдсан ашиг дансанд шууд шилжүүлж болно. Энэ нь тухайн хөрөнгийг актлах буюу данснаас хасах үед дахин үнэлгээний нэмэгдлийг бүхэлд нь шилжүүлэх ажиллагаа байж болно" гэсэн заалттай нийцүүлээгүй, өмнөх тайлант үеүдэд данснаас хассан хөрөнгөд хамаарах 1,364.3 сая төгрөг, тайлант хугацаанд хамаарах 207.4 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг данснаас хасахгүй тайлагнасан;
- СТОУС-15 Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого стандартын 31 "Аж ахуйн нэгж нь амласан бараа, үйлчилгээгээ худалдан авагчид нийлүүлснээр гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж нь орлогыг хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцүүлээгүй, өмнөх тайлант үеүдэд орлогоор хүлээн зөвшөөрөх 10 харилцагчтай холбоотой 7.3 сая төгрөгийг урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн, гэрээт ажлын хугацаа хэтэрсэнтэй холбоотойгоор гүйцэтгэгч 2 компанид 1.4 сая төгрөгийн алданги ногдуулсныг орлогоор хүлээн зөвшөөрөөгүй өр төлбөрөөр бүртгэсэн зэрэг нийт 8.7 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан;
- Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эздийн өмчийн бусад хэсэгт 5,708.8 сая, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулгын ангилалд 2,419.3 сая төгрөгийг тус тус дутуу, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулгын ангилалд тайлагнах 288.3 сая төгрөгийг бусад дэлгэрэнгүй орлогын ангилалд тайлагнасан;
- 2021 оны 4 дүгээр сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр дүрмийн сангийн хэмжээг 61,206.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гарсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй;
- Дансны авлагын ангилалд тайлагнах 50,523.9 сая төгрөгийг бусад авлагын ангилалд, дансны өглөгийн ангилалд тайлагнах 4,526.8 сая төгрөгийг бусад богино хугацаат өр төлбөрийн ангилалд, үндсэн хөрөнгийн ангилалд тайлагнах 146.7 сая төгрөгийг бусад эргэлтийн бус хөрөнгийн ангилалд тус тус зөрүүтэй тайлагнасан;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 4,478.5 сая төгрөгийн борлуулалтын орлогыг илүү тайлагнаж, тус орлогод ногдох 447.8 сая төгрөгийн НӨАТ-ын өрийг илүү тайлагнасан;
- Тайлант хугацаанд 27 харилцагчтай холбоотой 1,317.6 сая төлбөрийн цахим баримтыг дутуу, 1 харилцагчтай холбоотой 12.0 сая төгрөгийн төлбөрийн цахим баримтыг илүү гаргуулан авсан;
- Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актад тусгагдсан дүнгээс 124.0 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Тайлант хугацааны тогтмол зардлыг 69.0 сая төгрөгөөр илүү, 8.1 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;
- Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 135.6 сая төгрөгийн татвар ногдох орлогыг дутуу тайлагнасан.

### 8.2 Төлбөрийн акт

Анхан шатны баримтгүй 7.5 сая төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд тусгасан. Энэ нь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Шатахууны үнийг гэрээнд заасан үнээр тооцолгүй зах зээлийн үнээр худалдан авалт хийж нийт 247.6 сая төгрөгийг илүү шилжүүлсэн. Энэ нь Шатахуун нийлүүлэх №2020/261/ гэрээний 15.1 болон №2021/113 тоот гэрээний 15.1-д "нийлүүлэгч тал захиалагч талаас нэхэмжлэхдээ тендерт санал болгосон үнийг баримтална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Цар тахалтай холбоотойгоор хүнсний материалын үлдэгдэлд тооллогыг дутуу хийгдсэнээс шалтгаалан аудитын түүвэр тооллогоор 3.3 сая төгрөгийн бараа материал дутагдсан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 “Үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тооллогоор бэлэн байгаа үлдэгдэл, нягтлан бодох бүртгэлээр байвал зохих үлдэгдлийн хоорондын зөрүүг дор дурдсан журмаар тохируулан тооцно” 4/ “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Цахилгаан эрчим хүчний хөнгөлөлтийг төр хариуцан төлөхгүй 4 аж ахуйн нэгж байгууллагад 7.8 сая төгрөгийн хөнгөлөлт тооцсон. Мөн хэрэглэгчийн ангиллыг зөрүүтэй бүртгэснээс 7.6 сая төгрөгийн хөнгөлөлтийг дутуу тооцож, нийт 15.4 сая төгрөгийн хөнгөлөлт зөрүүтэй тооцсон байна. Энэ нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор батлагдсан "Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1 "Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 1-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Шүүхийн шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтныг буцаан томилж ажилгүй байх хугацааны нийт 26.4 сая төгрөг олгох шийдвэр гарч тайлант онд 4.3 сая төгрөг, 2022 онд 22.1 сая төгрөгийн цалинг тооцож олгосныг компаниас төлж барагдуулсныг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

### 8.3 Албан шаардлага

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 433.3 сая төгрөгийн авлагыг барагдуулах төлбөрийн акт тогтоосныг компанийн хөрөнгөөс барагдуулж, бэлтгэн нийлүүлэгч компаниудаас авлагыг цуглуулаагүй байсан асуудалд өмнөх аудитаар авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн  71 дүгээр зүйлийн 71.8-д “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

Өмнөх аудитаар хүргүүлсэн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой 205.9 сая төгрөгийн авлага, 279.8 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч,

худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

Өмнөх аудитаар хүргүүлсэн Засгийн газраас баталсан аргачлалын дагуу үнэлж биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх 51,747 метр квадрат 14 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгах, 27,827 метр квадрат 15 газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан сунгалтыг хийлгэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8-д "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

Өмнөх аудитаар өгсөн "ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2006 оноос хойшхи хугацаанд ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон 289.0 сая төгрөгийн өртөгтэй 8 орон сууцыг үндсэн хөрөнгөөр бүртгэн холбогдох элэгдлийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн" асуудлыг залруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй. Энэ нь НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандартын 7-д "Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: a. тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн аж ахуйн нэгжид орох нилээд их магадлалтай байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал***

**1.1** *Илрүүлэлт:*

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 34,188.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**1.2** *Өгсөн зөвлөмж:*

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн цаашид ашиглах хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлэх

***2. Орлогын бүртгэлтэй холбоотой асуудал***

**2.1** *Илрүүлэлт:*

Гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 2012 онд үүссэн 1,137.0 сая төгрөгийн урьдчилж орсон орлогыг өмнөх тайланд онуудад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэн, тус орлоготой холбоотой 577.0 сая төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Мөн тус гэрээт ажилтай холбоотой худалдан авсан 560.0 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг зарцуулаагүй удаан хугацаагаар ашиглалтгүй байна. Энэ нь СТОУС-15 Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого стандартын 31 “Аж ахуйн нэгж нь амласан бараа, үйлчилгээгээ худалдан авагчид нийлүүлснээр

гүйцэтгэлийн үүргээ биелүүлсэн тохиолдолд тухайн аж ахуйн нэгж нь орлогыг хүлээн зөвшөөрнө" гэсэн заалттай нийцэхгүй байна.

***2.2** Өгсөн зөвлөмж:*

Гэрээ дүгнээгүй, ажлыг гүйцэтгэж дуусаагүй үед орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн дүнг урьдчилж орсон орлогын данс руу залруулан бүртгэж, тус гэрээт ажилтай холбогдон гарсан зардлыг урьдчилж төлсөн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх;

***3. Эздийн өмчийн бүртгэлтэй холбоотой асуудал***

***3.1** Илрүүлэлт:*

Эздийн өмчийн бусад хэсэг дансанд тайлагнагдах 2,119.4 сая төгрөгийн газар эзэмших эрхийг дүрмийн сангаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар батлагдсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ын 5 дугаар бүлгийн 5.5-д "Газрын өмчлөх, эзэмших болон ашиглах эрхийг бүртгэлд тусгахдаа дараах бичилт хийнэ. Дт: Газар эзэмших/ашиглах эрх-Биет бус хөрөнгө Кт: Засгийн газрын сан/Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг" гэсэн заалттай нийцэхгүй байна.

***3.2** Өгсөн зөвлөмж:*

Дүрмийн сан нэмэгдүүлэх хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийг гаргуулахдаа газар эзэмших эрхийн дүнг оруулан тооцож, шийдвэрийг алдаатай гаргуулсныг залруулж, газар эзэмших эрхийг эздийн өмчийн бусад хэсэг данс руу шилжүүлэн бүртгэх;

***4. Татварын бүртгэлтэй холбоотой асуудал***

***4.1** Илрүүлэлт:*

Санхүүгийн тайланд татварын өрийн үлдэгдлийг 159.1 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Үнэн зөв байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

***4.2** Өгсөн зөвлөмж:*

Татварын тодорхойлолтод зөрүүтэй тусгагдсан шалтгааныг тодорхойлж, зөрүүг залруулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

***5. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал***

***5.1** Илрүүлэлт:*

Үйл ажиллагаанд ашиглахгүй удсан, насжилт өндөртэй 964.0 сая төгрөгийн бараа материалыг үнэ цэний бууралтаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, үр ашигтай ашиглах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Төрийн өмчийн төлөөлөгч дараах эрх үүрэгтэй: төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" гэсэн заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***5.2** Өгсөн зөвлөмж:*

Насжилт өндөртэй бараа материалыг эргэлтэд оруулж, үйл ажиллагаанд ашиглах, хөрөнгийг үр ашигтай зарцуулах арга хэмжээ авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Байгууллагын нэр | Аудитын код | Алдаа зөрчлийн утга | Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: Залруулга | | Үүнээс: Акт | | Үүнээс: Албан шаардлага | | Үүнээс: Үүнээс хариуцлага тооцох | | Үүнээс: Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар | | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Өмчийн өөрчлөлтийн тайлангийн эздийн өмчийн бусад хэсэгт 5,708,751.2 мянга, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулгын ангилалд 2,419,319.0 мянган төгрөгийг тус тус дутуу, нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулгын ангилалд тайлагнах 288,309.3 мянган төгрөгийг бусад дэлгэрэнгүй орлогын ангилалд тайлагнасан. Санхүүгийн тайлангийн тодруулгын үлдэгдлүүд зөрүүтэй, дутуу тайлагнасан зэргээр санхүүгийн тайланг тооцооллын алдаатай бэлтгэж толилуулсан. | Аудитын явцад залруулах | 1 | 8,416,379.5 | 1 | 8,416,379.5 | | | | | | | | |
| 2 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Орлогын татварын зардлыг 304,065.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан | Аудитын явцад залруулах | 1 | 304,065.0 | 1 | 304,065.0 | | | | | | | | |
| 3 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Хойшлогдсон татварын өр төлбөрийг холбогдох шийдвэргүй, тооцооллын алдаа гаргаж 3,076,045.9 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт алдааны залруулга данс руу хааж бүртгэсэн. | Аудитын явцад залруулах | 1 | 3,076,045.9 | 1 | 3,076,045.9 | | | | | | | | |
| 4 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Өмнөх тайлант үеүдэд данснаас хассан хөрөнгөд хамаарах 1,364,261.5 мянган төгрөг, тайлант хугацаанд хамаарах 207,432.5 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг данснаас хасаагүй байна. | Аудитын явцад залруулах | 1 | 1,571,694.0 | 1 | 1,571,694.0 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | 2021 оны 4 сарын Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр дүрмийн сангийн хэмжээг 61,206,416.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх шийдвэр гарсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй байна. | Аудитын явцад залруулах | 1 | 61,206,416.7 | 1 | 61,206,416.7 | | | | | | | | |
| 6 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Дансны авлагын ангилалд тайлагнах 50,523,923.0 мянган төгрөгийг бусад авлагын ангилалд, дансны өглөгийн ангилалд тайлагнах 4,526,803.0 мянган төгрөгийг бусад богино хугацаат өр төлбөрийн ангилалд, үндсэн хөрөнгийн ангилалд тайлагнах 146,723.9 мянган төгрөгийг бусад эргэлтийн бус хөрөнгийн ангилалд тус тус зөрүүтэй тайлагнасан. | Аудитын явцад залруулах | 1 | | 1 | | | | | | | | | |
| 7 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Өмнөх тайлант үеудэд орлогоор хүлээн зөвшөөрөх 10 харилцагчтай холбоотой 7,323.2 мянган төгрөгийн орлогыг урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн, гэрээт ажлын хугацаа хэтэрсэнтэй холбоотойгоор гүйцэтгэгч 2 компанид 1,421.1 мянган төгрөгийн алданги ногдуулсныг орлогоор хүлээн зөвшөөрөөгүй өр төлбөрөөр бүртгэсэн зэрэг нийт 8,744.3 мянган төгрөгийн орлогыг дутуу тайлагнасан. | Аудитын явцад залруулах | 1 | 8,744.3 | 1 | 8,744.3 | | | | | | | | |
| 8 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 4,478,519.2 мянган төгрөгийн борлуулалтын орлогыг илүү тайлагнаж, тус орлогод ногдох 447,851.9 мянган төгрөгийн НӨАТ-ын татварын өрийг илүү тайлагнасан. | Аудитын явцад залруулах | 1 | 447,851.9 | 1 | 447,851.9 | | | | | | | | |
| 9 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Тайлант хугацаанд 27 харилцагчтай холбоотой 1,317,578.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг дутуу, 1 харилцагчтай холбоотой 12,000.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг илүү гаргуулан авсан байна. | Аудитын явцад залруулах | 1 | 1,329,578.0 | 1 | 1,329,578.0 | | | | | | | | |
| 10 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актад тусгагдсан дүнгээс 124, 032.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан. | Аудитын явцад залруулах | 1 | 124,032.1 | 1 | 124,032.1 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/ НА-СТА-ТӨА | Тайлант хугацааны тогтмол зардлыг 69,025.1 мянган төгрөгөөр илүү, 8,070.9 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | Аудитын явцад залруулах | 1 | 77,096.0 | 1 | 77,096.0 | | | | | | | | |
| 12 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/ НА-СТА-ТӨА | Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 135,076.4 мянган төгрөгийн татвар ногдох орлогыг дутуу тайлагнасан. | Аудитын явцад залруулах | 1 | 135,076.4 | 1 | 135,076.4 | | | | | | | | |
| 13 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/ НА-СТА-ТӨА | Шатахууны үнийг гэрээнд заасан үнээр тооцолгүй зах зээлийн үнээр худалдан авалт хийж нийт 247,605.4 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн. | Гэрээнд заасан үнээр тооцоо хийж, зөрүүг нэхэмжлэн авах | 1 | 247,605.4 | | | 1 | 247,605.4 | | | | | | |
| 14 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/ НА-СТА-ТӨА | 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн 433,334.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах төлбөрийн акт тогтоосныг компанийн хөрөнгөөс барагдуулж, бэлтгэн нийлүүлэгч компаниудаас авлагыг цуглуулаагүй байсан асуудалд өмнөх аудитаар авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй. | Авлагыг барагдуулах арга хэмжээ авч, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж шийдвэрлэх | 1 | 433,334.5 | | | | | 1 | 433,334.5 | 1 | 433,334.5 | | |
| 15 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/ НА-СТА-ТӨА | Өмнөх аудитаар хүргүүлсэн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой 205,862.0 мянган төгрөгийн авлага, 279,840.6 мянган төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна. | Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах | 1 | 485,702.7 | | | | | 1 | 485,702.7 | 1 | 485,702.7 | | |
| 16 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/ НА-СТА-ТӨА | Өмнөх аудитаар хүргүүлсэн Засгийн газраас баталсан аргачлалын дагуу үнэлж биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх 51,747 метр квадрат 14 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгах, 27,827 метр квадрат 15 газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан сунгалтыг хийлгэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй. | Газар эзэмших эрхийг үнэлж бүртгэлд тусгах, хугацаа нь дууссан гэрчилгээний хугацааг сунгах ажлыг эрчимжүүлэх | 1 | | | | | | 1 | | 1 | | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Өмнөх аудитаар өгсөн "ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2006 оноос хойшхи хугацаанд ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон 289,045.0 мянган төгрөгийн өртөгтэй 8 орон сууцыг үндсэн хөрөнгөөр бүртгэн холбогдох элэгдлийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн" асуудлыг залруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй. | Ажилтнуудад олгосон үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах арга хэмжээ авч ажиллах | 1 | 289,045.0 | | | | | 1 | 289,045.0 | | | | |
| 18 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Анхан шатны баримтгүй 7,534.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд тусгасан. | Анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан зардлыг буцаан төлүүлж, улсын төсвийн дансанд төлж барагдуулах | 1 | 7,534.0 | | | 1 | 7,534.0 | | | | | | |
| 19 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 34,188,634.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй. | Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 34,188.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох | 1 | | | | | | | | | | 1 | |
| 20 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Гэрээт ажлыг бүрэн гүйцэтгэж дуусгаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй 2012 онд үүссэн 1,137,023.0 мянган төгрөгийн урьдчилж орсон орлогыг өмнөх тайланд онуудад орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэн, тус орлоготой холбоотой зарцуулагдсан 577,024.0 мянган төгрөгийн зардлыг үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Мөн тус гэрээт ажилтай холбоотой худалдан авсан 560,000.0 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг зарцуулаагүй байна. | Гэрээ дүгнээгүй, ажлыг гүйцэтгэж дуусаагүй үед орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн 1,137.0 сая төгрөгийг урьдчилж орсон орлогын данс руу залруулан бүртгэж, тус гэрээт ажилтай холбогдон гарсан 577.0 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх, зөрчлийг давтан гаргахгүй байх | 1 | 1,137,023.0 | | | | | | | | | 1 | 1,137,023.0 |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Санхүүгийн тайланд татварын өрийн үлдэгдлийг 159,145.2 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна | Татварын тодорхойлолтод зөрүүтэй тусгагдсан үлдэгдлийг залруулах арга хэмжээ авч ажиллан, зөрүүг залруулах | 1 | 159,145.2 | | | | | | | | | 1 | 159,145.2 |
| 22 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Бараа материалын үлдэгдэлд 1,152,523.1 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралт үүссэн гэж тооцон бараа материалын хасагдуулгаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Үүнээс насжилт өндөртэй буюу 10 жилээс дээш насжилттай 964,063.7 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй, бараа материалыг үр ашигтай зарцуулах, эргэлтэд оруулах арга хэмжээ авч ажиллаагүй байна. Бараа материалын нөөц бүрдүүлэн үр ашиггүй худалдан авалтууд хийсэн байна. | Насжилт өндөртэй бараа материалыг эргэлтэд оруулж, үйл ажиллагаанд ашиглах, хөрөнгийг үр ашигтай зарцуулах арга хэмжээ авч ажиллах | 1 | 964,063.7 | | | | | | | | | 1 | 964,063.7 |
| 23 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Цар тахалтай холбоотойгоор хүнсний материалын үлдэгдэлд тооллогыг дутуу хийгдсэнээс шалтгаалж аудитын түүвэр тооллогоор 3,284.0 мянган төгрөгийн бараа материал дутагдсан. | Тооллогоор илэрсэн дутагдлыг улсын төсвийн дансанд төлж барагдуулах | 1 | 3,284.0 | | | 1 | 3,284.0 | | | | | | |
| 24 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Цахилгаан эрчим хүчний хөнгөлөлт эдлэхгүй 4 аж ахуйн нэгж байгууллагад 7,756.0 мянган төгрөгийн хөнгөлөлт эдлүүлсэн. Мөн хэрэглэгчийн ангиллыг зөрүүтэй бүртгэснээс 7,652.8 мянган төгрөгийн хөнгөлөлтийг дутуу тооцож, нийт 15,428.8 мянган төгрөгийн хөнгөлөлт зөрүүтэй байна. | Хөнгөлөлтийг зөрүүтэй эдлүүлснийг улсын төсвийн дансанд төлж барагдуулах | 1 | 15,428.8 | | | 1 | 15,428.8 | | | | | | |
| 25 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Шүүхийн шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтныг буцаан томилж ажилгүй байх хугацааны нийт 26,384.2 мянган төгрөг олгох шийдвэр гарч тайлант онд 4,342.2 мянган төгрөг, 2022 онд 22,042.0 мянган төгрөгийн цалинг тооцож олгосныг компаниас төлж барагдуулсныг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна. | Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоодсон ажилтанд олгосон нөхөн төлбөрийг буруутай этгээдээс гаргуулан авч улсын төсвийн | 1 | 26,384.2 | | | 1 | 26,384.2 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дансанд төлж барагдуулах | | | | | | | | | | | |
| 26 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Эздийн өмчийн бусад хэсэг дансанд тайлагнагдах 2,119,234.3 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг дүрмийн сангаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн. | Дүрмийн сан нэмэгдүүлэх хувьцаа эзэмшигчдийн шийдвэрийг гаргуулахдаа газар эзэмших эрхийн дүнг оруулан тооцож, шийдвэрийг алдаатай гаргуулсныг залруулж, газар эзэмших эрхийг эздийн өмчийн бусад хэсэг данс руу шилжүүлэн бүртгэх | 1 | 2,119,234.3 | | | | | | | | 1 | 2,119,234.3 |
| ДҮН | | | | | 26 | 82,584,764.6 | 12 | 76,696,979.8 | 5 | 300,236.4 | 4 | 1,208,082.2 | 3 | 919,037.2 | 5 | 4,379,466.2 |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал | | | | | | | | | | | | | | | |
| 1 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Өмнөх оны аудитаар хүргүүлсэн худалдан авах ажиллагааны үнэлгээг хуульд заасны дагуу үнэлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 1,699.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээг буруу хийсэн. | Тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт бүрээр үнэлгээг үнэн зөв хийх | 1 | 1,699,534.4 | | | | | 1 | 1,699,534.4 | 1 | 1,699,534.4 | | |
| 2 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Өмнөх аудитаар хүргүүлсэн шилэн дансны мэдээллийг хуулийн дагуу иж бүрэн байршуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 625,304.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг дутуу байршуулсан. | Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, | 1 | 625,304.0 | | | | | 1 | 625,304.0 | 1 | 625,304.0 | | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Илүү цагийн нэмэгдэл олгох хязгаарыг хэтрүүлэн 6.6 сая төгрөгийн илүү цагийн хөлс тооцож олгосон. Хамтын гэрээнд хэвийн бус нөхцлийн ажилтнуудад хамаарах амралтын хоногийг хөдөлмөрийн хуулинд зааснаас 1 хоногоор илүү амраахаар заасан. Тайлант онд цахилгаан, дулааны төлбөрийг төр хариуцан төлсөн байхад нийт 233.5 сая төгрөгийн "халаалтын улирлын хөнгөлөлт"-ийг бүх ажилтан болон ахмадуудад засгийн газрын хөнгөлөлттэй давхардуулан олгосон. Мөн нийт орон тооны 38.3 хувь нь удирдах, ахлах ажилтнууд эзэлсэн буюу удирдах ажилтнууд олон дэд захирлууд болон алба, хэлтсийн дарга нарын ажлын ачаалал эрс ялгаатай байна. | Илүү цагийн нэмэгдэл хөлсийг дотоод журамд заасан хязгаарт багтаан олгох, ээлжийн амралт эдлэх хоногийг хөдөлмөрийн хуульд заасантай нийцүүлэх, шагнал, урамшуулал, тэтгэмжийг хавтгайруулан их хэмжээгээр олгохгүй байх, удирдах ажилтнуудын үр дүн, хариуцаж буй ажил үүргийг үнэлэн удирдах ажилтнуудыг нэмэгдүүлэхгүйгээр, гүйцэтгэх ажилтан руу шилжүүлэх байдлаар орон тоо зардлыг хэмнэж ажиллах | 1 | 240,088.4 | | | | | | | | | 1 | 240,088.4 |
| 4 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | Цалингийн зардлыг 312,403.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан. Оны тэргүүний ажилтнуудыг шалгаруулан шилдэг ажилтнууд болон алба, хэлтэст 129,600.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал олгосон, бэлэг дурсгалын зардалд 85,634.0 мянган төгрөгийг зарцуулсан. | Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоолыг мөрдөж ажиллан, тэвчиж болох бүх зардлыг тэвчиж, зардлыг хэмнэх, зөрчлийг давтан гаргахгүй байх, | 1 | 527,637.0 | | | | | 1 | 527,637.0 | | | | |
| 5 | Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | АХГ-2022/91/НА-СТА-ТӨА | ЭХЗХ-ны 2017 оны 199 дүгээр тоот тогтоолоор "Гэр хорооллын өрхөд цахилгаан эрчим хүчний тарифийн хөнгөлөлт үзүүлэх журам"-ын дагуу Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Нийслэлийн болон аймгийн төв, арван мянгаас дээш хүн амтай сум, суурин газрын гэр хорооллын хоёр тарифт тоолууртай өрхийн орой, шөнийн цагт хэрэглэсэн цахилгааны тарифыг хөнгөлж, тайлант онд дунджаар 120279 хэрэглэгчийг | Хөнгөлөлт олгох журмыг дахин нягталж, дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд журамд шинэчлэлт өөрчлөлт оруулах, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах арга | 51 | | | | | | | | | | 1 | |

| | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөнгөлөлтөд хамруулан 16,088,400.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг эдлүүлсний 1.2 хувийг хамарсан 1504 хэрэглэгч нь нийт хөнгөлөлтийн 11.6 хувь буюу 1,860,300.0 мянган төгрөгийг, 98.7 хувийг хамарсан 118,775 хэрэглэгч нь 88.7 хувь буюу 14,228,000.0 мянган төгрөгийн хөнгөлөлтийг эдэлсэн. Гэр хороололд амьдардаг иргэдийн дийлэнх нь халаалтаа цахилгаанаар хангах шийдлийг гаргах хөрөнгийн эх үүсвэргүйгээс хөнгөлөлтөд хамрагдаж чадаагүй, харин хотын гадна цэвэр агаарын бүсэд амьдарч буй өндөр хэрэглээтэй хувийн орон сууц, хаус, хотхонд амьдарч буй төлбөрийн чадвартай иргэд дийлэнх хөнгөлөлтийг эдэлсэн байна. Мөн хөнгөлөлтийн төлбөрийн эх үүсвэр нь ЭХЯ-аар дамжин БОАЖЯ-ны агаарын бохирдлыг бууруулах сангаас төлөгддөг бөгөөд оны эцсийн байдлаар 13,675,100.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, өмнөх оноос 2 дахин өссөн бөгөөд тус үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, тулган баталгаажуулалтын захидлын хариугаар баталгаажихгүй байна. Үүнээс үзэхэд хөнгөлөлтийн зорилго хангалтгүй хөнгөлөлт эдлэх шаардлагатай хэрэглэгчид хөнгөлөлтийг эдлэх боломж хязгаарлагдмал, эх үүсвэр хүрэлцэхгүй их хэмжээний авлагатай байхад хөнгөлөлтийн ихэнх хувийг төлбөрийн чадвартай иргэд эдэлсэн, утааг их хэмжээгээр үйлдвэрлэж буй ихэнх хэрэглэгч амьдардаг гэр хорооллын иргэд цахилгаанаар дулаанаа шийдэх боломжгүй байгаагаас утаа буурахгүй байгаа байдалд судалгаа, шинжилгээ, дүгнэлт хийгээгүй байна. | хэмжээ авч ажиллах, эх үүсврийг тодорхой болгох | | | | | | | | | | | | |
| **Дүн** | | | | | **5** | **3,092,563.8** | **0** | **0.0** | **0** | **0.0** | **3** | **2,852,475.4** | **2** | **2,324,838.4** | **2** | **240,088.4** |
| **НИЙТ ДҮН** | | | | | **31** | **85,677,328.4** | **12** | **76,696,979.8** | **5** | **300,236.4** | **7** | **4,060,557.6** | **5** | **3,243,875.6** | **7** | **4,619,554.6** |

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2022 оны 03 дугаар сарын 15 № 122/А0150055 Улаанбаатар хот

АХГ-2022/91/НА-СТА-ТОА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шатахууны үнийг гэрээнд заасан үнээр тооцолгүй зах зээлийн үнээр худалдан авч, нийт 247,838,975.00 төгрөгийг илүү шилжүүлсэн.

Энэ нь Шатахуун нийлүүлэх №2020/261 гэрээний 15.1 болон №2021/113 тоот гэрээний 15.1 "нийлүүлэгч тал захиалагч талаас нэхэмжлэхдээ тендерт санал болгосон үнийг баримтална" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Шатахууны төлбөрт илүү шилжүүлсэн 247,838,975.00 /хоёр зуун дөчин долоон сая найман зуун гучин найман мянга есөн зуун далан тав/ төгрөгийг гаргуулан авч, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Төрийн банкан дахь 102100001204 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Дагдан, Ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

9006109
9019120396

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Akt\2022\0315 Auditin 4 Gazar-54.Docx

0001090280

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 121/А0150055 Улаанбаатар хот

АХГ-2020/91/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны баримтгүй 7,468,705.00 төгрөгийн ажил, гүйлгээг хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд тусгасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй зарцуулсан 7,468,705.00 /долоон сая дөрвөн зуун жаран найман мянга долоон зуун тав/ төгрөгийн зардлыг буцаан төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Дагдан, Ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 120/А0150055 Улаанбаатар хот

АХГ-2022/91/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цар тахалтай холбоотойгоор хүнсний материалын үлдэгдэлд тооллогыг дутуу хийсэн, аудитын түүвэр тооллогоор 3,284,000.00 төгрөгийн хүнсний материал дутагдсан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл "Эд хөрөнгийн тооллого явуулах журам"-ын 4 "үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Тооллогоор дутагдсан 3,284,000.00 /гурван сая хоёр зуун наян дөрвөн мянга/ төгрөгийг буруутай этгээдээр төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Дагдан, Ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ Ц.НАРАНЧИМЭГ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХОСЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР Т.ОДОНЧИМЭГ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 4 Gazar-56.Docx

0001090284

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 119/А0150055 Улаанбаатар хот

АХГ-

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу гүйцэтгэсэн Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цахилгаан эрчим хүчний төлбөрийг төр хариуцан төлөхгүй 4 аж ахуйн нэгж, байгууллагад 7,776,055.00 төгрөгийн хөнгөлөлт тооцсон, хэрэглэгчийн ангиллыг зөрүүтэй бүртгэснээс төр хариуцан төлөх төлбөрийг 7,652,694.00 төгрөгөөр дутуу тооцсон.

Энэ нь Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор баталсан "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" тогтоолын 1 "Айл өрхийн болон дор дурдсанаас бусад аж ахуйн нэгж, байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, дулааны уур хэрэглэсний төлбөр, цэвэр, бохир усны үйлчилгээний төлбөр болон энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс тооцож 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд төрөөс хариуцан төлөх арга хэмжээг зохих журмын дагуу авч хэрэгжүүлэх..." гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Цахилгаан эрчим хүчний төлбөрийг төр хариуцан төлөх хэмжээг зөрүүтэй тооцсон 15,428,749.00 төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Дагдан, Ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ | Ц.НАРАНЧИМЭГ |
| ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.ХОСЖАРГАЛ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | |
| МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Т.ОДОНЧИМЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*



0001090286

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 118/2013005 Улаанбаатар хот

АХГ-2022/91/ХА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шүүхийн шийдвэрээр ажлаас чөлөөлөгдсөн 1 ажилтныг буцаан томилж, ажилгүй байх хугацааны цалин нийт 26,415,830.00 төгрөг олгох шийдвэр гарч, тайлант онд 4,291,699.00 төгрөг, 2022 онд 22,124,131.00 төгрөгийн цалинг тооцож, компаниас төлж барагдуулсныг буруутай этгээдээр төлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь**:

1. Шүүхийн шийдвэрээр ажлаас үндэслэлгүй халагдсан нь тогтоогдсон ажилтанд олгосон 26,415,830.00 /хорин зургаан сая дөрвөн зуун арван таван мянга найман зуун гуч/ төгрөгийн нөхөн төлбөрийг буруутай этгээдээс гаргуулан авч, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкан дахь Аудитын шалгалтын орлого 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Дагдан, Ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

9006109
9019120396

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2022\0315 Auditin 4 Gazar-58.Docx

0001090288

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 №516/2015 0055 Улаанбаатар хот
АХГ-2022/31/НА-СТА-ТОА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн шилэн дансны мэдээллийг хуулийн дагуу иж бүрэн байршуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан 625,304,000.00 төгрөгийн бараа, ажил үйлчилгээний нэр санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг дутуу байршуулсан.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” 6 дугаар зүйлийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Өмнөх аудитаар хүргүүлсэн шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Хангамж үйлчилгээний албаны дарга Ш.Оюунчимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Дагданд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Т.ОДОНЧИМЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

9019120396

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-205.Docx

0001081390

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 518/А0150055 Улаанбаатар хот
АХГ-2022/31/НА-СТА-ТОА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн худалдан авах ажиллагааны үнэлгээг тендерийн баримт бичигт заасны дагуу үнэлэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 1,699,534,425.00 төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтын үнэлгээг буруу хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 "Үнэлгээний хороо байнгын бус ажиллагаатай байх бөгөөд дор дурдсан чиг үүрэгтэй байна", 47.2.2 "тендерийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргах, гэрээ байгуулах эрх олгох шийдвэрийг захиалагчид өгөх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн тендер шалгаруулалтын үнэлгээг тендерийн баримт бичигт заасны дагуу үнэлэх албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Хангамж үйлчилгээний албаны дарга Ш.Оюунчимэгт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Дагданд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ Ц.НАРАНЧИМЭГ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХОСЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР Т.ОДОНЧИМЭГ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 519/20150055 Улаанбаатар хот
АХГ-2022/31/НА-СТА-ТОА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн Засгийн газраас баталсан аргачлалын дагуу үнэлж биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх 51,747 метр квадрат 14 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгах, 27,827 метр квадрат 15 газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа дууссан сунгалтыг хийлгэх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8 "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн “Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах, үнэлгээ хийж бүртгэлд тусгах” албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга О.Ариунболдод хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Дагданд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-203.Docx

0001081384

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 03 дугаар сарын 15 № 520/2015055 Улаанбаатар хот
АХГ-2022/31/ЖА-СТА-ТОА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар хүргүүлсэн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотой 205,862,018.19 төгрөгийн авлага, 279,840,652.76 төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Өмнөх оны аудитаар өгсөн авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга О.Ариунболдод хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Дагданд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ Ц.НАРАНЧИМЭГ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХОСЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР Т.ОДОНЧИМЭГ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-202.Docx

0001081386

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 03 дугаар сарын 15 № 521/A0150055 Улаанбаатар хот
АХГ-2022/91/НА-СТА-ТӨА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 433,334,508.74 төгрөгийн авлагыг барагдуулах төлбөрийн акт тогтоосныг компанийн хөрөнгөөс барагдуулж, бэлтгэн нийлүүлэгч компаниудаас авлагыг цуглуулаагүй асуудалд авлагыг барагдуулах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.8 “өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн бэлтгэн нийлүүлэгчээс авах авлагыг барагдуулах албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга Б.Баттүшигт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Дагданд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-201.Docx

0001081382

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
# АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 522/A0150055 Улаанбаатар хот
АХГ-2022/91/НА-СТА-ТОА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлыг батлагдсан төсвөөс 312,400,000.00 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, шилдэг ажилтнууд болон алба, хэлтэст 129,600,000.00 төгрөгийн шагнал урамшуулал олгосон, бэлэг дурсгалын зардалд 85,696,000.00 төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.3 "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Батлагдсан төсөвт зардлыг хэтрүүлэхгүй, төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллан, зардлыг хэмнэж, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Дагдан, Ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ХОСЖАРГАЛ
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Т.ОДОНЧИМЭГ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 03 дугаар сарын 15 № 523/20150055 Улаанбаатар хот
АХГ-2022/31/НА-СТА-ТОА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн "ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 2006 оноос хойшхи хугацаанд ажилтнуудад орон сууцны дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй нөхцлөөр олгосон 288,967,346.00 төгрөгийн өртөгтэй 8 орон сууцыг үндсэн хөрөнгөөр бүртгэн холбогдох элэгдлийг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн" асуудлыг залруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 16 "Үндсэн хөрөнгө" стандартын 7 "Үндсэн хөрөнгийн өртгийг зөвхөн дараах тохиолдолд хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө: а.тухайн хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн үр өгөөж нь тухайн аж ахуйн нэгжид орох нилээд их магадлалтай байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Ажилтнуудад олгосон үл хөдлөх хөрөнгийг данснаас хасах арга хэмжээ авч ажиллан, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Р.Дагдан, Ерөнхий нягтлан бодогч О.Ариунболд нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

| | |
|---|---|
| АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | Ц.НАРАНЧИМЭГ |
| АУДИТЫН МЕНЕЖЕР | Ц.ХОСЖАРГАЛ |
| МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ | Т.ОДОНЧИМЭГ |

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ТЭМДЭГЛЭЛ

ТЭМДЭГЛЭЛ

.........................................................................................................................................................

.........................................................................................................................................................

.........................................................................................................................................................